



Монгол Улсын Засгийн газар

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН
ОЮУ ТОЛГОЙ, ХӨХ ХАД, МАНАХТ, УЛААН УУЛЫН
ТАЛБАЙД 2003 ОНД ХИЙХ ХАЙГУУЛЫН БОЛОН
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2003 он



Айвенхоу Майнз Монголия Инк.

Ч.Форстер
Д.Гарамжав
С.Санждорж
Т.Мөнхбат

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН
ОЮУ ТОЛГОЙ, ХӨХ ХАД, МАНАХТ, УЛААН УУЛЫН
ТАЛБАЙД 2003 ОНД ХИЙХ ХАЙГУУЛЫН АЖЛЫН
УРЬДЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хайгуулын ажлын төлөвлөгөөг хянасан:
Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын

Геологийн албаны мэрэгжилтэн

Б.Сүнжидмаа

УМХГ-ын ГУУХ-ын Улсын байцаагч

Л.Цэвээнравдан

Хайгуулын ажлын төлөвлөгөөг хүлээлгэн өгсөн:
Айвенхоу Майнз Монголия Инк.
компанийн геологич

Д.Гарамжав

УЛААНБААТАР ХОТ
2003 он

ГАРЧИГ

1. Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайнуудад 2003 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө
2. Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайнуудын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

ХАВСАРГАСАН ЗУРГУУД

- Зураг 1. Хайгуул хийх талбайнуудын тойм зураг
Зураг 2. Хайгуул хийх талбайнуудын геологийн зураг

ХАВСАРГАСАН МАТЕРИАЛУУД

1. Оюу толгойн лицензийн хуулбар хавсралтуудын хамт
2. Манахтын лицензийн хуулбар хавсралтуудын хамт
3. Хөх хадны лицензийн хуулбар хавсралтуудын хамт
4. Улаан уулын лицензийн хуулбар хавсралтуудын хамт

ХАВСАРГАСАН ХҮСНЭГТ

1. 2003 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө

Оюутолгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайд 2003 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөл

Ажлын төрөл	Нэгж	Нэгж	Оюу толгой		Манахт		Хөх хад		Улаан уул		Дүн	
			Тоо	Үнэ,долл	Тоо	Үнэ,долл	Тоо	Үнэ,долл	Тоо	Үнэ,долл	Тоо	Үнэ,долл
1 Бэлтгэл ажил			1	1,000.00	1	100.00	1	100.00	1	1,000.00	4	2,200.00
	СПОТ, ЛАНДСАТ-ын зураг	зураг										
2 Хээрийн хайгуул												
	Зураглай	х.д.км										
	Маршрут	одр			3	1,500.00	2	1,000.00	5	2,500.00	10.00	5,000.00
3 Геофизикийн ажил												
	Соронзон хайгуул	км										
	Албадмал туйлшрал	х.д.км	5	2,500.00								
4 Сорьлолт												
	хөрсний	шир										
	чулуулгийн	шир										
5 Өрөмдлөг												
	Алмазан өрөмдлөг(металлургийн туршигтын)	туун м	2000	140,000.00								
	Алмазан өрөмдлөг (хүрээ тогтоох)	туун м	80000	8,000,000.00							80,000.00	8,000,000.00
6 Топо зураглай												
		км	30									0.00
7 Байгаль орчны ерөнхий судалгаа												
	Байгаль орчны нөхөн сэргээлт	ам.дол	5000	5,000.00								5,000.00
8 Тээвэр:												
	Хүн	ам.дол	500	500.00								500.00
	Хайгуулын ангийн хүнс, сорьц	км	0.12	112,320.00	300	36.00	100	12.00	1000	120.00	937,400.00	112,488.00
9 Хоол хүнс												
	Хайгуулын ангийн хүнс, сорьц	т/км	561600	101,088.00							561,600.00	101,088.00
	хүн-өл/доллар	хүн-өл/доллар	10	7,200.00							720.00	7,200.00
10 Лабораторийн ажлууд												
	Хээрийн ажлын дүн	Доллар		8,369,608.00		1,636.00		1,112.00		3,620.00		8,375,976.00
	Лабораторийн ажлууд											
	Керний сорьцын геохимийн шинжилгээ	сорьц	20	800,000.00								800,000.00
	Чулуулгийн сорьц	сорьц	400	8,000.00	100	2,000.00	100	2,000.00	100	2,000.00	700.00	14,000.00
	Хөрсний сорьц	сорьц	20				20	400.00				400.00
11 Лабораторийн ажлуудын дүн												
	Лабораторийн ажлуудын дүн	Доллар		808,000.00		2,000.00		2,400.00		2,000.00		814,400.00
	Нийт дүн	Доллар		9,177,608.00		3,636.00		3,512.00		5,620.00		9,190,376.00

ОРШИЛ

Оюу толгойн лицензийн талбай (66X/210) нь (106°47'30"/42°58'30", 106°47'30"/43°03'00", 106°55'00"/43°03'00", 106°55'00"/42°58'30") Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс баруун урагш 45км зайд орших ба 10.3км*8.5км буюу 8665 км² талбайтай (1-р Хавсралт, 1-р Зураг).

Манахтын лицензийн талбай (66X-1) (106°38'00"/42°54'00", 106°38'00"/42°57'00", 106°44'00"/42°57'00", 106°44'00"/42°54'00" цэгүүдийг холбосон шугамаар хязгаарлагдсан 4537 га буюу 8км*6км хүрэхгүй хэмжээтэй бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс баруун урагш 65 км зайд оршино (1-р Зураг).

Хөх хадны лицензийн талбай (66X-2) нь (106°51'30"/42°55'30", 106°51'30"/42°57'30", 106°55'00"/42°57'30", 106°55'00"/42°55'30" цэгүүдийг холбосон шугамаар хязгаарлагдсан 1762 га буюу 4км*5км хүрэхгүй хэмжээтэй бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс баруун урагш 55 км зайд оршино (1-р Зураг).

Улаан уулын лицензийн талбай (66X-3) нь (106°30'00"/42°54'00", 106°30'00"/43°00'00", 106°36'00"/43°00'00", 106°36'00"/42°54'00" цэгүүдийг холбосон шугамаар хязгаарлагдсан 9070 га буюу 8км*11км хүрэхгүй хэмжээтэй бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс баруун урагш 70 км зайд оршино (1-р Зураг).

Оюу толгойн талбай нь Ундайн гол ба Дугатын голын хуурай сайруудаар хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 1155-1180м, орой нь хавтгай ба бөмбөгөр хэлбэртэй, цав толгод, тэгш тал хосолсон газарт оршино. Энд говийн бор, цөлийн карбонатлаг бор саарал хөрс зонхилон тархсан ба энэ нь нимгэн давхаргатай, ялзмагийн зүйлээр бага боловч эрдэс давс агуулсан байна. Ургамлын бүрхэвч сийрэг боловч туурайтан, мэргэгчид, жигүүртэн, хэвлээр явагч амьтад цөөнгүй байдаг. Агаарын жилийн дундаж хэм 3.2-3.7⁰С байдаг. Зунд 50⁰ хүртэл халж өвөлд -39⁰ хэм хүртэл хүйтэрдэг. Сумын төвд засаг захиргааны байгууллага, шуудан холбооны салбар, дэлгүүр, сургууль, гуанз, улаан булан, халуун ус, зочид буудал, эмнэлгийн салбартай. Аймгийн төвөөс Ханбогд сумын төв хүртэл 250км орчим зайтай бөгөөд шороон замаар холбогддог, утсан холбоотой.

1. Оюу толгойн районы геологийн тогтоцын товч тодорхойлолт

Оюу толгойн талбай нь Ханбогд уулаас (1351м өндөр) баруун тийш 15 км зайд Цэрдийн болон Гуравдагчийн тунамал хурдсаар хучигдсан өргөн хөндийн дунд орших Девоны настай бялхмал чулуулгийн гидротермаль хувирал бүхий жижиг илэрц юм. Оюу толгой нь 1:200000 масштабын геологийн зураг дээр зэсийн илэрц гэж тэмдэглэгдсэн байдаг. Энэ талбайн баруун хойт, хойт, өмнөд ба төв хэсэгт Силурын ба Силур-Девоны цаг үеийн ангилагдаагүй вулканоген чулуулаг тархжээ. Талбайн баруун өмнөд, төв ба зүүн өмнөд хэсэгт Карбоны цаг үеийн тунамал болон интрузив чулуулаг тархсан байна. Энэ талбайн ихэнх хэсгийг Цэрд-гуравдагч-дөрөвдөгчийн тунамал хучаас хурдас эзэлж байна. (Зураг 2).

Интрузив чулуулгийн хувьд Оюу толгойн районы өмнөт хэсэгт Силур, Девоны хурдсыг зүсч гарсан Девоны сиенит, хойт хэсэгт Карбоны боржин тархсан байна. Оюу толгойн зэсийн хүдэржилт үндсэндээ Девоны цаг үеийн хувирсан андезит, андезит-базальт (?), дацит, риолит дотор ерөнхийдөө баруун хойш чиглэлтэй томоохон хагарлын бүсэд үүссэн байна. Уг илрэл зүүн талаасаа Цэрд-гуравдагч-дөрөвдөгчийн тунамал хурдсаар, баруун талаасаа Доод Цэрдийн хурдсаар хучигдсан байна.

2. Хайгуулын ажлын арга, аргачлал, дэс дараалал, хэмжээ

2003 онд тус компани Оюу толгой, Манхт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайнуудад хайгуулын ажил явуулах боловч ихэнх ажлаа Оюу толгойн ордны хүрээнд төвлөрүүлнэ. Энд уг ордын (Алс Хойт, Төв болон Өмнөд Оюу толгойн орчимд) геологи-структурын онцлогийг нарийвчлан судлах, хүдрийн биетүүдийн хэлбэр, хэмжээ, эрдсүүдийн тархалтын зүй тогтол болон прогнозын нөөцийг тодорхойлох, уг нөөцөөс металл ялгах технологи боловсруулах зорилт тавьж байна. Айвенхоу Майнз Монголия Инк. нь төсөл, төсөв, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хээрийн судалгааны ажлыг бүрэн гүйцэтгэж, энэ ажлаа дууссаны дараа судалгаа явуулсан талбайнхаа байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэж орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгөхөөс гадна судалгааны ажлын үр дүнгийн тайланг тогтоосон хугацаанд нь АМХЭГ-т хүлээлгэн өгнө.

2.1. Геодези, байр зүйн зургийн ажил

Энэ онд тус талбайнуудад геодези, байр зүйн зургийн ажил хийхгүй боловч өрөмдсөн цооногуудын амсрыг дифференциал GPS ашиглан тодорхойлно.

2.2. Алмазан өрөмдлөгийн ажил

2002 онд хийсэн өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн алмазан өрөмдлөг хийнэ. Өрөмдлөгийн цэгүүдийг өмнөх жилүүдэд хийсэн албадмал туйлширал, соронзон ба грави хайгуул, геологийн судалгаа болон өрөмдлөгийн ажлын үр дүнд үндэслэн тогтооно. Энэ ажлын хэмжээ ойролцоогоор 80 цэгт нийтдээ 80000м байх болно. Алмазан өрөмдлөгийг эргэлтийн аргаар ойролцоогоор 36-100мм голчтой үзүүрийн багаж ашиглан хийнэ. Өрөмдлөгийн кернд газар дээр нь документаци хийж уг цооногийн зүсэлтийг гаргах ба кернийг тусгай хайрцагт хийж Оюу толгойд таллан хувааж нэг хэсгийг компанийн агуулахад хадгалж нөгөө хэсгийг нь 1-2м урттай хэрчмүүдээр хуваан сорьцолж лабораторийн шинжилгээ хийлгэнэ.

Талбайн геологийн бүтэц, структур, тектоникийн талаарх мэдээллийг Spot image, Landsat зэрэг сансрын хиймэл дагуулаас авсан 1:100000, 1:50000, 1:25000-ын хураангуйлалтай өнгөт зургуудаас авна.

2.3. Тээвэр

Судалгааны ажил дуустал хээрийн хайгуулын ангийн байр, багаж хэрэгсэл, материал Оюу толгойн ангийн төвд хадгалагдах ба тус ангийн үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж, материалыг автомашинаар хүргэнэ. Тээвэрлэх нийт ачааны хэмжээ ойролцоогоор 1400 тонн байна. Улаанбаатараас Оюу толгой хүртэл талдаа 630 км орчим зам туулна. Тээвэрт Зил-130, Камаз автомашин оролцох ба хээрийн судалгааны ажлын явцад Тоёото, УАЗ-469 машинууд ажиллана. Өрөмдлөгийн ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгэх тул тээврийн зардлыг энд оруулаагүй болно. Тайлант онд ойролцоогоор 940000 т/км ачаа тээврийн ажил хийнэ.

2.4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

Тус компани нь ажиллагсдын ажиллах орчин нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангаж тэдний эрүүл мэнд, аюулгүй ажиллах дээд зэргийн нөхцөл бүрдүүлнэ. Энэ үүргээ биелүүлэхийн тулд Айвехой Майнз Инк компанийн мөрддөг стандартаас гадна Монгол улсын холбогдох хууль тогтоомж, журам, стандартыг баримтлана. Хээрийн судалгааны ангийн төвийг тус компанийн Улаанбаатар,

Ванкувер, Бангкок хот дахь байрруудтай харилцах сансрын холбооны төхөөрөмж, Улаанбаатартай богино долгионы радио холбоогоор хангасан.

2.5. Байгаль орчныг хамгаалах ажил

- Айвехой Майнз Инк компани нь байгалийн нөөц баялаг хангах үйл ажиллагаа явуулдаг учраас байгаль орчныг хамгаалах талаар стандартын дээд түвшинд хүрэх бодлого баримталдаг. Хээрийн ажлын турш байгаль орчныг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөг аль болох багасгах арга хэмжээ авч ажиллана.

Энэ талбайд хийх нийт ажлын хэмжээг дараахи хүснэгтэд харуулав.

ОЮУ ТОЛГОЙ, МАНАХТ, ХӨХ ХАД, УЛААН УУЛЫН ТАЛБАЙНУУДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨСЛИЙН УРЬДЧИЛСАН ТОДОРХОЙЛОЛТ

(2003 оны 1 дүгээр сар)

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1 Төслийн нэр

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайнуудад хийх геологийн нарийвчилсан судалгааны ажил

1.2 Төслийн зорилго

Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайн геологи-структурын онцлогийг нарийвчлан судлах, хүдрийн эрдсүүдийн тархалтын зүй тогтол болон прогнозын нөөцийг тодорхойлох, ордыг олборлох технологи боловсруулахад шаардагдах нэмэгдэл мэдээлэл цуглуулах

1.3 Төслийн эцсийн бүтээгдэхүүн

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайн геологи-структурын онцлог, хүдрийн биетүүдийн хэлбэр хэмжээ, тогтсон гүн, эрдсүүдийн тархалтын зүй тогтол, урдчилсан таамаг нөөц баялаг, түүнийг олборлох технологийн талаар хийсэн судалгааны ажлын урьдчилсан дүгнэлт-тайлан.

1.4 Төсөл хэрэгжүүлэгч

Төслийг Айвенхоу Майнз Монголия Инк. компани хэрэгжүүлнэ.

1.5 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Сүхбааар дүүрэг, Олимпын гудамжны 6-р байшин

Утас: 976-11-310785, 312289, 310775

Факс: 976-11-312337 Email: sanjdorj@ivanhoemines.mn

1.6 Төсөл хэрэгжих талбайн байриил

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайнууд. Хайгуул хийх талбайн талаар дэлгэрэнгүй мэдээллийг "2003 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний төсөл"-өөс үзнэ үү.

1.7 Тогог төхөөрөмж (үндсэн)

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайнуудад хийх геологийн судалгааны ажлыг тус компанийн 14 геологич, гэрээгээр ажилллах 3 компанийн 60 орчим ажилчидын хүчээр хийхээс гадна энэ ажилд гадаад дотоодын лабораториуд, зөвлөх компаниуд оролцоно. Хайгуулын ажил жилийн турш явагдана. Хайгуулын ангийн үйл ажиллагааг хангах, хайгуулын ажил явуулахад

тээврийн болон суудлын тэрэг ашиглана. Оюу толгойн ордын талбайд 2003 онд 80 цэгт нийтдээ 80000м алмазан өрөмдлөг, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайд геологийн маршрутын судалгаа хийх юм. Геологийн судалгааны явцад чулуулгийн гарш, хөрс, кернээс авсан сорьцуудад геохимийн шинжилгээ хийлгэнэ. Геологийн судалгааны нийт ажлын хэмжээг "2003 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний төсөл"-өөс үзнэ үү.

1.8 Дэд бүтэц (ашиглагдаж буй)

Байхгүй

1.9 Тухайн бүс нутагт хэрэгжсн буй болон хэрэгжих бусад төсөл

Энэ бүс нутагт Монгол газар зэрэг хэд хэдэн компани геологийн хайгуулын төсөл хэрэгжүүлж байгаа мэдээ бий. Тус компани Оюу толгойн талбайгаас гадна хуучин энэ лицензийн талбайн хүрээнд байсан Хөх хад, Манахт, Улаан уулын талбайнуудад хайгуулын ажил явуулна.

1.10 Төслийн хэрэгжилтийн урьдчилсан хуваарь-график

Дээрх талбайд хийхээр төлөвлөсөн ажлуудаа 2003 оны 12 сард дуусгана.

Хоёр. Эдийн засгийн үзүүлэлтүүд

2.1 Хөрөнгө оруулалт

Тус компани энэ талбайд 2003 онд нийтдээ 3.0 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна.

2.2 Үйлдвэрлэлийн зардал

Үйлдвэрлэлийн зардал (ажилчдын цалин, лицензийн төлбөр, хайгуулын анги, тээвэр, байгаль орчны хамгааллын зардал оролцон) нийтдээ 5.0 сая ам.доллар болох тооцоо гарч байна. Оюу толгойн талбайд хийх ажлын зардлыг "2003оны хайгуулын ажлын төлөвлөгөөний төсөл"-өөс үз.

2.3 Нийт орлого

Эрэл хайгуулын ажлын шатанд орлого олохгүй.

2.4 Цэвэр ашиг

Эрэл хайгуулын ажлын шатанд цэвэр ашиг гарахгүй.

2.5 БОХ арга хэмжээний нийт зардал

Тус компанийн үйл ажиллагаанаас дээрх талбайн байгаль орчинд үзүүлэх нөлөөг тооцох нилээд хэцүү юм. Хээрийн судалгааны явцад хайгуулын ангийн үйлчилгээнд 1, геологийн судалгаанд 3 машин байнга ажиллахаас гадна хайгуулын ангийг хүнс, материалар хангахад 1 машин ашиглагдана. Эдгээр машинууд хуучин замуудыг ашиглана. Геологийн судалгааны машин зарим тохиолдолд замгүй явах боловч нэг явсан мөрөөрөө 2-оос илүү явах тохиолдол ховор байх учир үүнээс үүсэх эвдрэл бага

байна. Харин өрөмдлөгийн ажлын үед өрмийн болон үйлчилгээний том машин механизм ажиллан газрын хөрс болон хэвлийг хөндөх тул Оюу толгойн байгаль орчинд үлэмж нөлөө үзүүлнэ. Оюутолгойн талбайд өрөмдөх 80 цооногийн байгаль орчныг цэвэрлэн нөхөн сэргээхэд 500000 орчим төгрөг шаардагдана. Түүнээс гадна уг талбайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэнэ.

2.6 БОХ арга хэмжээний жилийн зардал

БОХ арга хэмжээнд 2003 онд 5500 ам.доллар зарцуулна.

2.7 Байгали орчин бохирдуулсны төлбөр, хураамж

Тус компанийн буруугаас байгаль орчин бохирдсон тохиолдолд ноогдох хариуцлагыг бүрэн хүлээнэ. Түүнээс гадна дээрх талбайнуудад ажиллах хугацаандаа ундны болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усныхаа төлбөр хураамжийг хууль тогтоомжийн дагуу орон нутгийн нэхэмжлэлээр төлнө.

Гурав. Төслийн үйл ажиллагаа, техникийн шийдлийн асуудал

3.1 Төслийн үйл ажиллагаа (технологийн)-ны бүдүүвч, схем

Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайнуудад хийх хайгуул судалгаа, өрөмдлөгийн ажлын явцад чулуулгийн гарш, цооног дээр ажиглалт, бичиглэл хийх ба байрлалыг GPS-ээр тогтооно. Энэ мэдээллийг ашиглан геологийн зураг схем зохионо.

3.2 Туслах үйл ажиллагааны тодорхойлолт

Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайнуудад хийх геологийн судалгааны явцад зарим чулуулгийн гарш дээр геологичдыг автомашинаар хүргэх буюу буцааж авна.

3.3 Түүхий эд, туслах материал:

а). Байгалийн баялаг

Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайд геологи, өрөмдлөгийн ажил хийх хайгуулын анги ойролцоогоор 60 хүн 360 хоног ажиллана. Энд ундны болон ахуйн хэрэгцээний усыг нэг хүнд 50л/хоног, өрөмдлөгт хоногт 8 м³ байхаар авав.

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Цэвэр ус	21600 хүн/өдөр * 0.05м ³ =1080 м ³	Худаг, булаг
Өрөмдлөгийн ус	(80 цооног) 1000 хон * 8 м ³ =8000 м ³	Худаг, булаг

б) Химийн бодис, материал

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Байхгүй		

в) Бусад

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Байхгүй		

3.4 Хог хаягдал, завсрын бүтээгдэхүүн

а) Завсрын бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Байхгүй		

б) Хатуу хог хаягдал

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Лааз, шил, яс	5 тонн	Хүнсний зүйлсийн сав

в) Шингэн хаягдал

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Ахуйн бохир ус	1070 м ³	Гал тогоо, шүршүүр, жорлон

г) Хийн хаягдал

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Байхгүй		

Дөрөв. Хог хаягдлын хяналт, удирдлага зохион байгуулалт

4.1 Хог хаягдал цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр

а) Хатуу хог хаягдал

Нэр төрөл	Цэвэрлэгээ	Зайлуулалт
Лааз, шил, яс	байнга	Улаанбаатарт авчирч хаягдлын цэгт өгнө

б) Шингэн хаягдал

Нэр төрөл	Цэвэрлэгээ	Зайлуулалт
Ахуйн бохир ус	байнга	Жорлон, нүх ухаж хийх ба дараа нь булна

в) Химийн хаягдал

Нэр төрөл	Цэвэрлэгээ	Зайлуулалт
Байхгүй		

4.2 Химийн бодисын хадгалалт

Нэр төрөл	Цэвэрлэгээ	Зайлуулалт
Байхгүй		

4.3 Цацраг идэвхт хог хаягдал түүний цэвэрлэгээ

Нэр төрөл	Цэвэрлэгээ	Зайлуулалт
Байхгүй		

Тав. Нийгмийн асуудал

5.1 Ажиллах хүчний тоо, мэргэжлийн ангилал, шаардлага

Тус компанийн хайгуулын анги нь ангийн дарга, геологичид, тогооч жолооч нараас бүрдэх боловч гэрээгээр ажиллаж байгаа компанийн ажилчид нийлээд 150–200 хүнтэй болно.

5.2 Ажиллах хүчний эх үүсвэр

Тус компанийн гадаад дотоодын эксперт мэргэжилтнүүд болон гэрээгээр ажиллах компаний ажилтан ажилчид

5.3 Ажиллагсдын нийгмийн асуудлын шийдвэрлэлт

Компани хээрийн үйлдвэрлэлийн үед ажиллагсадыг өдөрт гурван удаа халуун хоолоор ханган бүх ажилд өөрийн унаагаар үйлчилж түр орон сууц, хөнжил гудас, сансрын телефон болон радио холбоогоор бүрэн хангана. Хайгуулын ангийн төвд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тоног төхөөрөмж, эм бэлдмэлээр бүрэн хангагдсан нэг их эмч байнга ажиллуулна. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу ажиллагсдын эрүүл мэнд, нийгмийн болон бусад даатгалыг хариуцна.

Зургаа. Төсөл хэрэгжих газар нутгийн суурь нөхцөл байдал

Хүн ам сийрэг нутагладаг, аймаг болон сумын төвөөс алс зайдуу, дэд бүтэц буурай хөгжсөн, зам харгуй муутай газар оршдог. Оюу толгой Ханбогд сумын төвөөс 45км зайтай. Сумын төвд эмнэлэг, холбооны салбар, дэлгүүр, шатахуун түгээх газартай.

6.1 Агаарын бохирдлын асуудал (үндсэн үзүүлэлтээр)

Агаарын бохирдол байхгүй боловч ерөнхийдөө хуурай, шороон шуурга их шуурдаг, тоос нилээд ихтэй.

6.2 Усны бохирдлын асуудал (гүний болон гадаргын усны үндсэн үзүүлэлтээр)

Газар доорх ус нь бохирдол байхгүй боловч бага гүнтэй, усны төвшин дээртэй худгууд нь малын шивтрээр бага зэрэг бохирдсон, ихэнх худгийн ус эрдэсжилт нилээд өндөр учир ундаанд хэрэглэхэд тохиромж муутай.

6.3 Хөрсний бохирдлын асуудал (бохирдлын үндсэн асуудал, эвдрэл)

Худгуудын ойролцоох газруудын хөрсийг эс тооцвол хөрсний бохирдол байхгүй. Хүний үйл ажиллагаанаас нөлөөлсөн эвдрэл байхгүй

6.4 Цаг уурын үндсэн үзүүлэлтүүд

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Хавар салхи ихтэй, үе үе ширүүсэн шороогоор шуурдаг, зун нь 30–40°C хүртэл халуун, өвөлд 30–35°C хүртэл хүйтэрдэг ба жилд дунджаар 50–100мм тунадас унадаг.

6.5 Газар зүйн (геологийн тогтоц) үндсэн тодорхойлолт

Дээрх талбайнууд нь физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаардаг, газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтдаг байна. Геологийн хувьд уг талбай нь 1:200000 масштабтай геологийн зургаар бүрэн, зарим хэсэг нь 1:50000 масштабтай геологийн зургаар бүрхэгдсэн байна.

6.6 Газар эдэлбэрийн хэлбэр

Байгалийн онцлог байдлаас шалтгаалан газар тариалан хөгжүүлэх боломжгүй бөгөөд харин малын бэлчээрт ашиглах боломжтой.

6.7 Ургамлын аймаг

Ургамал газрын хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд тачир сийрэг ургадаг боловч тэжээллэг чанар сайтай. Ихэвчлэн бутлаг ургамал ургана. Хонхор буюу сайрын хоёр талаар хайлаас ургах ба агь, шарилж, харгана цав толгодыг бүрхэнэ. Нам дор, хотгор газруудаар дэрс ургана.

6.8 Ойн бүрхэвч

Ойн бүрхэвч байхгүй боловч том сайруудын дагуу хайлаас ургадаг.

6.9 Амьтны аймаг

Ургамлын бүрхэвч сийрэг боловч туурайтан, мэрэгчид, жигүүртэн, хэвлээр явагч амьтад цөөнгүй байдаг. Туурайтнаас зээр, хулан, хар сүүлт тааралдана. Мэрэгчдээс туулай, алаг даага, хулгана, зараа, хэвлээр явагчдаас гүрвэл, могой, шавьжаас аалз, арваалж, хилэнцэт хорхой, жигүүртнээс болжмор, бүргэд, харцага, тас, сар тааралдана.

6.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Манай талбайн урд хилээс холгүй Говийн бага дархан газар байдаг.

6.11 Соёл, шинжлэх ухааны дурсгал

Одоогоор Оюу толгойн орчимд 2001–2002 онд хийсэн археологийн судалгааны явцад эртний соёл иргэншлийн үлдэгдэл, соёл, шинжлэх ухааны холбогдолтой нилээд олон газар байгаа нь илэрсэн байна.

6.12 Дэд бүтэц

Энэ талбайд дэд бүтэц хөгжөөгүй бөгөөд нутгийн малчид тэмээ, хонь, ямаа, адуу голлон малладаг. Сумуудын төвд эмнэлэг, сургууль, холбоо, телевизийн станц болон шатахуун түгээгүүрийн станцтай.

6.13 Нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, бүтэц

Энэ районы эдийн засаг төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд өмч хувьчлалын дараа үүссэн тархай бутархай, амины мал аж ахуй зонхилдог.

Долоо. Байгаль орчны талаар баримтлах бодлого

Тус компани нь байгаль орчныг хамгаалах талаар дараахи зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:

- Судалгаа хийх талбайнхаа ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж түүнийг бохирдохоос сэрэмжилнэ.
- Эргүүлэн ашиглах боломжгүй бүх төрлийн хог хаягдлыг ялаа, шувуу, мал орохооргүй таглаатай нүхэнд цуглуулан хийж булна.
- Эргүүлэн ашиглах боломжтой бүх хог хаягдлыг Улаанбаатарт тээвэрлэн авчирч ийм төрлийн хаягдал цуглуулах цэгт тушаана.
- Худаг, булаг шанд болон усан хангамжийн бүх эх үүсвэрийг бохирдохоос хамгаална.
- Тээврийн бүх хэрэгслийг тусгайлан бэлтгэсэн газар зогсоож тос, шатахуун асгахаас сэргийлнэ.
- Байр болон судалгааны талбайд хяналтгүй гал гаргахаас сэрэмжилж гал түймрээс болгоомжилно.
- Байгаль орчны асуудлаар орон нутгийн захиргаа, олон нийтийн байгууллагатай нягт хамтран ажиллаж энэ ажилд өөрийн зүгээс хувь нэмэр оруулахаас гадна энэ талаар төлөвлөгөө боловсруулан орон нутгийн захиргаа, холбогдох албаар батлуулан түүнийгээ мөрдөж ажиллана.
- Түүх, археологийн судалгаа үргэлжлүүлэн хийж цаашид тэднийг хамгаална.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны талаар үнэлгээ хийж зөвлөлгөө өгөх “ЭКО ТРАДЕ”, “ЭКОС” компануудын боловсруулсан Байгаль орчны ерөнхий болон урьдчилсан үнэлгээний тайлангуудыг ашиглав.